



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/47/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn Ахлах аудитор: Н.Бадамхатан Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn Аудитор: М.Нарангэрэл Утас: 325093 Цахим хаяг: narangerelm@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 326
танай _____-ны № _____-Т

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.МӨНХБАЯР ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

00202203

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 86.5 хувийн хэрэгжилттэйгээр гүйцэтгэн, тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

© Desktop-2024\Word\Scan_Saver\2024-02-23 11:14\ulama_haamjin_pazar.docx

2.Аудит хийсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	97,689,000.00	756,946,170.05
33	Авлага	97,689,000.00	756,946,170.05
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	634,577,841.89
33500	Бусад авлага	2,745,000.00	2,745,000.00
33510	Байгууллагаас авах авлага	2,745,000.00	2,745,000.00
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	94,944,000.00	119,623,328.16
33730	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	29,160,000.00	23,560,000.00
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	19,784,000.00	15,373,328.16
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих		47,190,000.00
33723	Гэрээт малчин төслийн санхүүжилт	46,000,000.00	33,500,000.00
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн (II)	-	-
3	Нийт хөрөнгийн дүн (III=I+II)	97,689,000.00	756,946,170.05
4	Нийт өр төлбөр (IV)		
5	Цэвэр хөрөнгө, өмчийн дүн (V)	97,689,000.00	756,946,170.05
51	Засгийн газрын хувь оролцоо	97,689,000.00	756,946,170.05
51200	Хуримтлагдсан үр дүн	97,689,000.00	756,946,170.05
51210	Өмнөх үеийн үр дүн	97,689,000.00	97,689,000.00
51220	Тайлант үеийн үр дүн		659,257,170.05
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн (VI=IV+V)	97,689,000.00	756,946,170.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үйл ажиллагааны орлогын дүн (I)	3,490,415,400.00	1,502,866,500.00
13	Тусламж, санхүүжилтийн орлого	3,490,415,400.00	1,502,866,500.00
1310	Улсын төсвөөс	3,490,415,400.00	1,502,866,500.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	3,490,415,400.00	1,502,866,500.00
2	Үйл ажиллагааны зардлын дүн (II)	3,806,705,543.00	843,609,329.95
21	Урсгал зардал	3,806,705,543.00	843,609,329.95
210	Бараа,үйлчилгээний зардал	2,998,410.00	116,958,490.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,998,410.00	116,958,490.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	2,998,410.00	116,958,490.00
213	Урсгал шилжүүлэг	3,803,707,133.00	726,650,839.95
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,807,887,840.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,807,887,840.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	26,220,671.84
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	26,220,671.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	995,819,293.00	700,430,168.11
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	995,819,293.00	700,430,168.11
3	Үйл ажиллагааны үр дүн (III=I-II)	(316,290,143.00)	659,257,170.05
4	Үйл ажиллагааны бус орлогын дүн (IV)	-	-
5	Үйл ажиллагааны бус зардлын дүн (V)	-	-
6	Үйл ажиллагааны нийт үр дүн(VI=III+IV-V)	(316,290,143.00)	659,257,170.05

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн (I)	3,884,705,543.00	1,502,866,500.00
12	Татварын бус орлого	394,290,143.00	-
1200	Нийтлэг татварын бус орлого	394,290,143.00	-
120009	Бусад нийтлэг татварын бус орлого	394,290,143.00	-
13	Тусламж, санхүүжилтийн орлого	3,490,415,400.00	1,502,866,500.00
1310	Улсын төсвөөс	3,490,415,400.00	1,502,866,500.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	3,490,415,400.00	1,502,866,500.00
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн (II)	3,884,705,543.00	1,530,187,171.84
21	Урсгал зардал	3,884,705,543.00	1,530,187,171.84
210	Бараа, үйлчилгээний зардал	2,998,410.00	116,958,490.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,998,410.00	116,958,490.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	2,998,410.00	116,958,490.00
213	Урсгал шилжүүлэг	3,881,707,133.00	1,413,228,681.84
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,807,887,840.00	634,577,841.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,807,887,840.00	634,577,841.89
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	26,220,671.84
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	26,220,671.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,073,819,293.00	752,430,168.11
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,073,819,293.00	752,430,168.11
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (III=I-II)	-	(27,320,671.84)
14	Үйл ажиллагааны бус орлого	-	27,320,671.84
9	Санхүүгийн үйл ажиллагааны орлогын дүн	-	27,320,671.84
145	Бусад орлого (олз)	-	27,320,671.84
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-	27,320,671.84
7	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (VII)	-	27,320,671.84
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ(VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын капитал	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	-	97,689,000.00	97,689,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	97,689,000.00	97,689,000.00
C08	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	97,689,000.00	97,689,000.00
D01	2023 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	-	97,689,000.00	97,689,000.00
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	97,689,000.00	97,689,000.00
D03	Тайлант үеийн үр дүн	-	659,257,170.05	659,257,170.05
D08	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	756,946,170.05	756,946,170.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,502,866,500.00	869,388,658.11	633,477,841.89	57.8
21	Урсгал зардал	1,502,866,500.00	869,388,658.11	633,477,841.89	57.8
210	Бараа, үйлчилгээний зардал	180,500,000.00	116,958,490.00	63,541,510.00	64.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний хураамж	180,500,000.00	116,958,490.00	63,541,510.00	64.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	180,500,000.00	116,958,490.00	63,541,510.00	64.8
213	Урсгал шилжүүлэг	1,322,366,500.00	752,430,168.11	569,936,331.89	56.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,322,366,500.00	752,430,168.11	569,936,331.89	56.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж	1,322,366,500.00	752,430,168.11	569,936,331.89	56.9
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр				
1310	Улсын төсвөөс	1,502,866,500.00	869,388,658.11	633,477,841.89	57.8
131006	ЗГ-ын тусгай сангаас санхүүжих	1,502,866,500.00	869,388,658.11	633,477,841.89	57.8

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,000.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Түрээсийн хөнгөлөлт эдлэх шаардлага хангаагүй 10 иргэнд хөнгөлөлт эдлүүлсэн.	1	15,000.0					1	15,000.0
Дүн	1	15,000.0					1	15,000.0

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.